

**Шалтгааны  
утгатай угсарсан  
нийлмэл  
өгүүлбэрийн  
холбогдсон аргыг  
тодорхойлох**

**1**

**Өмнөх мэдлэгийг сэргээн санах**

**2**

**Өгүүлбэрүүдийг хэв шинжээр нь ялган таних**

**3**

**Шалтгааны утгат нийлмэл өгүүлбэрийн тухай мэдэх**

**4**

**Шалтгааны утгат нийлмэл өгүүлбэрийг хэрэглэх**

# Дараах эхийг уншихдаа тодруулсан асуултад хариулагдах өгүүлбэрийг олоорой.


*Ус хамгийн их нууц агуулсан шингэн*

*Яагаад усыг чандмань эрдэнэ гэдэг вэ?*

*Ус нь бие махбодын 70-80 хувийг эзэлнэ. Уураг тархины 90 хувийг бүрдүүлнэ. Бие махбодын бүх эсийг сэргээж, энергиэр тэтгэнэ. Хүч тамирыг сэргээдэг тул ядаргааг тайлна. Цангааг хамгийн сайн тайлна. Анхаарлын төвлөрлийг сайжруулснаар хөдөлмөрлөх чадварыг дээшлүүлнэ. Бүх төрлийн хүнсний зүйлийн хамгийн их уусгагч болно. Хамгийн шилдэг эм болдог. Усыг хэзээ, хэдий хэмжээгээр уухаа тохируулбал илүүдэл жингүй, гоолиг байна. Хөгширөлтийн явцыг хянаж, арьсыг эрүүл, толигор байлгана. Кофе, алкогольд шунах муу зуршлаас ангижруулна. Харшил, багтрааг анагаах хамгийн ердийн арга болно...*

*Мэдээжийн ийм их “хүч чадал” усанд байдаг учраас түүнийг эрдэнэтэй зүйрлэхээс өөр яах билээ.*





Яагаад усыг  
чандмань  
эрдэнэ гэдэг

ВЭ?  
ВЭ?

- Бие махбодын бүх эсийг сэргээж, энергиэр тэтгэнэ.
- Хүч тамирыг сэргээдэг тул ядаргааг тайлна.
- Цангааг хамгийн сайн тайлна.
- Анхаарлын төвлөрлийг сайжруулснаар хөдөлмөрлөх чадварыг дээшлүүлнэ.
- Бүх төрлийн хүнсний зүйлийн хамгийн их уусгагч болно.
- Хамгийн шилдэг эм болдог. Усыг хэзээ, хэдий хэмжээгээр уухаа тохируулбал илүүдэл жингүй, гоолиг байна. Хөгшрөлтийн явцыг хянаж, арьсыг эрүүл, толигор байлгана.
- Кофе, алкогольд шунах муу зуршлаас ангижруулна.
- Харшил, багтрааг анагаах хамгийн ердийн арга болно.

Мэдээжийн ийм их “хүч чадал” усанд байдаг  
учраас түүнийг эрдэнэтэй зүйрлэдэг.

# Хоёр эгнээнд байгаа өгүүлбэрүүдийг ажиглаад, энгийн, нийлмэл өгүүлбэрийг ялгааг тайлбарлаарай.

Өгүүлбэрийн бүтэц	Энгийн өгүүлбэр	Нийлмэл өгүүлбэр
<p><b>Жишээ</b></p>	<p>Ус нь бие махбодын 70-80 хувийг эзэлнэ. Цангааг хамгийн сайн тайлна. Бүх төрлийн хүнсний зүйлийн хамгийн их уусгагч болно. Хамгийн шилдэг эм болдог.</p>	<p>Бие махбодын бүх эсийг сэргээж, энергиэр тэтгэнэ. Хүч тамирыг сэргээдэг тул ядаргааг тайлна. Анхаарлын төвлөрлийг сайжруулснаар хөдөлмөрлөх чадварыг дээшлүүлнэ. Усыг хэзээ, хэдий хэмжээгээр уухаа тохируулбал илүүдэл жингүй, гоолиг байна. Хөгшрөлтийн явцыг хянаж, арьсыг эрүүл, толигор байлгана. Кофе, алкогольд шунах муу зуршлаас ангижруулна. Харшил, багтрааг анагаах хамгийн ердийн арга болно.</p>
<p><b>Тайлбар</b></p>	<p>Дээрх өгүүлбэрүүд нь ..... учраас энгийн өгүүлбэр болно.</p>	<p>Дээрх өгүүлбэрүүдэд ихэвчлэн ..... нийлж, өгүүлбэр бүтээсэн тул нийлмэл өгүүлбэр болно.</p>

# Өгүүлбэрийн заагласан хэсэг тус бүрийн асуултыг ажиглаарай.

Яаснаас? Ямар учраас? Яагаад?

Яана?

- Бие махбодын бүх эсийг сэргээж, энергээр тэтгэнэ.
- Хүч тамирыг сэргээдэг тул ядаргааг тайлна.
- Анхаарлын төвлөрлийг сайжруулснаар хөдөлмөрлөх чадварыг дээшлүүлнэ.
- Усыг хэзээ хэдий хэмжээгээр уухаа тохируулбал илүүдэл жингүй, гоолиг болно.



Асуулт

Яагаад? Яаснаас? Ямар учраас?  
Юуны учир? Юунаас болж? ...

Бүтэц

Төгс бус өгүүлбэр+ төгс өгүүлбэр

# Тодруулсан холбох хэрэглүүр ямар утга илэрхийлж байгааг тайлбарласан тайлбарыг анхааралтай уншиж, тэмдэглээрэй.



# Онолын ойлголтыг дэвтэртээ тэмдэглэж аваарай.

## Тодорхойлолт

Нийлмэл өгүүлбэрт үйл явдал дараалж болоход аль нэг нь илүү гол үүрэгтэй байдаг. Эхний үйл явдал нь дараагийн үйл явдал бүтэхийн үндэс болж, **төгс бус өгүүлэхүүнээр илэрсэн өгүүлбэрийг** шалтгааны утгат өгүүлбэр гэнэ.

### Бүтэц

**Төгс бус өгүүлбэр** + **төгс өгүүлбэр**

### Холбох хэрэглүүр

**Нөхцөлөөр:** - вал4, -бал4,- хлаар4, -ж, -ч, -н, -аад4, -сан4+ аас, -сан4+ аар

- **Холбох үгээр:** учраас, тул, тулд, учир, улмаас, бол...

### Асуулт

Яагаад? Ямар учраас? Юуны учир? Яаж? Яавал?  
Яахлаар? Яаснаас? Яаснаар? Юуны тул?

### Жишээ

**Сүүдрээ** хараад сүхээ барина.

**Сүүлээ** хараад соёогоо харуулна.

**Мэдээжийн ийм их “хүч чадал” усанд байдаг учраас** түүнийг эрдэнэтэй зүйрлэхээс өөр яах билээ.

### Тайлбар

Эхний хэлц өгүүлбэрт байгаа хоёр өгүүлбэрийн аль аль нь хардах сэрдэх гэсэн утгатай бөгөөд үйлийн –аад нөхцөл нь дараах үйл буюу сүхээ барих, соёогоо харуулах гэсэн үйлийн бүтэх шалтгаан болно.

# Дараах өгүүлбэрт тохирох холбох хэрэглүүрийг сонгож, цэгийн оронд бичээрэй.

1. Тархины цусан хангамж нь эсэд хэрэгцээтэй усыг өгч чадахгүй (...) толгой өвдөн, бие сульдаж эхэлнэ.

- бол
- учир

2. Хоол боловсрох явцад хоол хүнс нь уснаас энерги авдаг (...) та гайхах хэрэггүй.

- тул
- улмаас

3. Хэрэв ус дутагд(...) өөхний задрал явагдахгүй (...) жин хуримтлагдана.

- ж
- хлаар

4. Иймд усны дутагдлыг нөхөхийн зэрэгцээ ферментүүдийг идэвхжүүлэх үүрэгтэй эрдэс, амин дэмийг зохистой хэрэглэ(...) хур өөхнөөсөө сал(...), хэвийн жинтэй болдог.

- вал4
- аад4



# Өгүүлбэрийг зөв харгалзуулж, шалтгаан үрийн утгыг илэрхийлээрэй.

Хүслийг хангагч эрдэнэ, эр хүний нөхөр, наадам цэнгэлийн бахархал гэж бэлгэшээдэг.

1

Уруугаа харсан савтай адилтган, буян хишиг нь асгарна хэмээн үздэг.

2

Айл гэрийн голомт ариун дагшин байх учиртай.

3

Хүний сүлд хийморь нь шингэсэн байдаг.

4

Аян замд саад тотгор, гай барцад тохионо гэж цээрлэдэг.

5

а

Монголчууд мандах төрийн малгай, бүтэх төрийн бүс хэмээн дээдэлдэг.

б

Монгол хүн адууг эрхэмлэн дээдэлдэг.

в

Хол замд яваа хүн зогсоогоороо цай ууж, идээ амсдаггүй.

г

Галд хог новш, элдэв муу зүйл хийхийг цээрлэнэ.

д

Хүнд малгай бэлэглэхийг цээрлэдэг.



# Дараах өгүүлбэрүүдээс шалтгаан, үрийн утгатай нийлмэл өгүүлбэрийг ялган тэмдэглээрэй.

Саруул талын явган шуурга үлээгээд, агсам хурдан хүлэг тэнхээ мэдэн тэмүүлнэ.

Тавдугаар сарын дунд үеэр зөөлөн бороо орж, ногоо ургалаа.

Түүх гэдэг бол хүнийг унтах гэж зүүрмэглэхэд үргэлж сэрээгээд эхэлдэг “хэл мэдэхгүй хүүхэд” юм.

Хар усан нуур хар болор мэт мэлтрэн, хаяа хөвөөний нь зэгс шагшуурга халиу суусрын сор шиг гэрэлтэнэ.

Хүйтэн цагийн жихүүн салхи үхэрчин хүүтэй тэмцэлдээд, хөлдүү мөсөн оргилууд оройн наранд туяараад, хөндий жалгаар үхэр сүрэг алхална.

Өргөн сайхан талын дунд уяхан эгшиг хангинаж, уургын үзүүр үе үе жирвэлзэнэ.

Хурц үгнээс ул мөр үлддэг бол бид нил шарх сорви явах сан.

Ах дүү, зочин гийчин хэдийнээ одон, аниргүй уйтгарлаг ноёлно.

# Тохирох шалтгааны утгатай өгүүлбэрээр дэлгэрүүлж, “Эрүүл, аюулгүй хоол хүнсний 5 түлхүүр” зөвлөгөөг бүтээгээрэй.

Цэвэр байлга.

1. .... хоол хүнсийг бохирдуулдаг.

Чанасан болон түүхий хүнсийг тусад нь хадгал.

2. .... тэдгээрийн шүүсэнд агуулагддаг бичил биетүүд холилдож бохирддог.

Хоол хүнсийг гүйцэд чанаж болго.

3. .... аюултай бүх бичил биет устдаг.

Хоол хүнсийг зохих хэмд хадгал.

4. .... хоол хүнсийг тасалгааны хэмд хадгалж болохгүй.

Аюулгүй ус, хүнсний түүхий эд сонго.

5. .... заавал угааж хэрэглэнэ.

А. Аливаа хүнсний түүхий эд нь химийн бодист бохирдсон байж болох учир

Б. Хүнс бэлтгэх, хадгалах явцад өөр өөр төрлийн түүхий махыг хамт байлгавал

В. Өвчин үүсгэгч бичил биетүүд нь бохир гар, алчуур, хувцас, багаж хэрэгслээр дамжин

Г. Хоол хүнсийг гүйцэд чанаснаар

Д. Бичил биетүүд нь 50-60 хэмд идэвхтэй үржиж, хор ялгаруулдаг учраас

# Гэрийн даалгавар:

Дараах баримтыг ашиглан, учир шалтгаан, үр дагаврыг харуулсан өгүүлбэр зохиогоорой. Дараа нь дараалалд оруулан зөвлөгөө бичээрэй.

